

“АЖИЛЧДЫН МАНЛАЙЛАЛ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГИЙН ТАЙЛАН

Үйл ажиллагааны зорилго нь:

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болсон хүүхэд бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааг бүтээлчээр хөтлөн явуулж буй шилдэг ажилчдын туршлагыг түгээн дэлгэрүүлэх, харилцан суралцах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

Хан-Уул дүүргийн “Цахирмаа” бүсээс “Ажилчдын манлайлал” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 үе шаттайгаар үйлчлэгч, манаач, слесарь, эмч, нярав, нягтлан бодогч гэсэн мэргэжлээр бүс, дүүргийн хэмжээнд 2017 оны 01-р сарын 30-аас 02-р сарын 16-ны хооронд зохион байгуулж явуулахад төрийн өмчийн 28-н цэцэрлэгийн нийт 478 хүн хамрагдсан байна.

Дүүргийн хэмжээнд НБГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн СӨБ хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхзаяа, Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Ж.Отгонхорлоо, СӨБ хариуцсан мэргэжилтэн Ж.Шинэбаяр, “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын эрүүл ахуйч Н.Энхбуд, KRKA, ГЕДСОН эмийн компани, 28-н цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, үйлчлэгч, манаач, слесарь, эмч, нярав, нягтлан бодогч нар оролцлоо. Өдөрлөгийн үеэр “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-мэргэжилтэн эрүүл ахуйч Н.Энхбуд, “Хүнсний бүтээгдэхүүнийг зөв зохистой хадгалах нь”, KRKA, ГЕДСОН эмийн компаниуд “Витамины зохистой хэрэглээ” сэдэвт сургалтуудыг явуулж NTV, ETV телевизүүдээр сурталчиллаа.

Өдөрлөгөөр тухайн мэргэжлийн хүмүүс ажлын байрны гол онцлог, ур чадвараа үзүүлсэн төдийгүй хүн бүрийн өөрсдийн давуу тал, авьяасаараа хүүхдийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг нээн харуулсан үр дүнтэй ажил байлаа. Үүнийг дугуйлан хичээлүүлэх, тоглоом наадгай хийх, орчинг тохижуулах, уралдаан зохион байгуулах зэрэг ажлуудаас нь харж болохоор байлаа.

Өдөрлөгийн хүрсэн үр дүн:

1. Мэргэжил нэгт нөхдөөсөө суралцан, шинэлэг санаануудыг ажилдаа бүтээлчээр хэрэгжүүлэн, нэвтрүүлэх санаа олж авсан.
2. Мэргэжил тус бүрийн давуу тал, сул тал, боломж, бэрхшээл зэргийг ярилцаж санаа бодлоо солилцож шийдвэрлэх арга замаа эрэлхийлсэн.
3. Цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.
4. Өөрсдийн ажил, гарын ур дүй, авьяас чадвараараа бахархсан, нээлттэйгээр танилцуулсан.
5. Хүүхдийг хөгжүүлэхэд маш их нөөц боломж, хүч байдгийг мэдэрсэн, өөрсдийн нөөцөөр харилцан биедээ туслах, хамтрах санал солилцсон.

“Оюуны ундраа” бүсийн цэцэрлэгүүд “Үйлчлэгчийн манлайлал”

218-р цэцэрлэг 10:00 цаг



“Цахирмаа” бүсийн цэцэрлэгүүд “Эмчийн манлайлал”

Клиник 4-р сувилал 12:00 цаг





“Хатан туул” бүсийн цэцэрлэгүүд “Манаач, слесарийн манлайлал”

209-р цэцэрлэг 14:00 цаг



“Буянт ухаа 2” бүсийн цэцэрлэгүүд “Няравын манлайлал”

219-р цэцэрлэг 10:00 цаг



“Буянт ухаа 1” бүсийн цэцэрлэгүүд “Нягтлан бодогчын манлайлал”

230-р цэцэрлэг 12:00 цаг





Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр оролцогчдоос санал асуулга авч нэгтгэлээ.

“Цахирмаа” бүсээс зохион байгуулсан “Ажилчдын манлайлал” нээлттэй хаалганы өдөрлөг хэр үр дүнтэй болсон бэ? гэсэн санал асуулгад маш сайн гэж 76 хувь, сайн гэж 23 хувь, дунд зэрэг гэж 1 хувь санал өгчээ.

Өдөрлөгийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг үнэлнэ үү? гэсэн асуулгад

Цаашид өөрийн үйл ажиллагаандаа тусгах шинэлэг санааг энэхүү өдөрлөгөөс авч чадсан уу? гэсэн асуулгад тийм гэж 100 хувь санал өгсөн байна.

Цаашид та ажилдаа юуг тусгаж ажиллах вэ? гэсэн санал асуулгад

1. Их зүйлийг сурч, мэдэж авлаа хэмээн 12 хувь;
2. Бага насны хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх тоглоом, хэрэглэгдэхүүн хийнэ гэж 8 хувь;
3. Зөвхөн баримлын шаварыг ашиглаж сургалтын хэрэглэгдэхүүн хийх сургалтыг авмаар байна хэмээн 3 хувь;
4. Монгол зан заншил, өв уламжлалаа өвлүүлэн үлдээх тогтоом хэрэглэгдэхүүн хийсэн манаач нарын ажлыг хэрэгжүүлэх гэж 11 хувь;
5. Хөгжмийн энгийн зэмсгийг гарын доорх материалаар хийж өгнө хэмээн 9 хувь;
6. Бөхийн дугуйлан хичээллүүлж буй 189 дүгээр цэцэрлэгийн манаачийн ажлыг туршлага болгон ажиллана гэж 13 хувь;
7. Цэцэрлэгүүдийн гадна тохижилт, тоглоомыг хийх гэж 5 хувь;
8. Няравуудын санаачлан хийдэг цай, шөлний орцийг авч ашиглах гэж 14 хувь;
9. Эмч нарын судалгааг төрөлжүүлсэн байдлыг ажлын туршлага болгоно хэмээн 15 хувь;

10. ХКС-4-ийн их эмчийн хийдэг бага насны хүүхдийг чийрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ хэмээн 10 хувь нь санал өгсөн байна.

Энэ үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулах хүсэлтэй байгаа эсэх гэсэн асуулгад тийм гэж 85 хувь, үгүй гэж 15 хувь санал өгсөн байна.